

**ЧОЙЖИ-ОДСЭР БА “ДӨРВӨН МУТАРТ МАХАГАЛИЙН МАГТААЛ”  
ШҮЛГИЙН УРАН САЙХНЫ ЗАРИМ ОНЦЛОГ**

Г. Галбаяр<sup>1</sup>

Чойжи-Одсэр хэмээх нэгэн их бичгийн хүн XIV зууны эхний хагаст буюу Хайсан Хүлэг (1307-1311), Буянт (1311-1320) хааны төр барьж байх үед ажиллаж амьдарч, ном зохиолоо туурвиж байжээ. Бичгийн түшмэл түүний намтар түүх, уран бүтээлийн талаар Шаравсэнгийн орчуулсан “Бурханы арван хоёр зохионгуйн үйлс” (XIV зууны 10-20-иод оны үед орчуулсан), нэр нь үл мэдэгдэх зохиогчтой “Чакарвардын алтан хааны тууж” (1607 оны орчим), Лувсанданзаны “Алтан товч” (1634), Цахарын Лэгдэн хаан (1604-1634)-ы үед түүний зарлигаар орчуулсан “Монгол Ганжуур”-ын зарим боть (2-р ботийн 218-р талд, 11-р ботийн 331-р талд, 70-р ботийн 269-р талд, 82-р ботийн 80-81-р талд), Саган Сэцэний “Эрдэнийн товч” (1662), Жамбын “Асрагч нэртийн түүх” (1677), Данзандагвын “Богд Чойжи-Одсэрийн зохиосон Зүрхэний толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч огторгуйн маань” (XVIII зууны эхний хагас), Дарма гүүшийн “Алтан хүрдэн мянган хэгээст” (1739), Жанжаа хутагт Ролбийдорж (1717-1786)-ийн удирдлагаар зохиогдсон “Мэргэд гарахын орон” (1741), нэр нь үл мэдэгдэх зохиогчтой “Сав шим хийгээд хаадын уг” (XVIII зууны сүүлийн хагас), Жамбадоржийн “Болор толь” (1834-1837), ... зэрэг монгол хэлээрх, Сүмбэ хамбо Ишбалжирын “Энэтхэг, Хятад, Төвд, Монголын оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсны Галбарбаасан модон хэмээх оршив” (1748), Натагийн “Алтан эрих” (1817), Лувсанцэмбэлийн “Их Монголын оронд дээдийн ном ямар мэт гарсан ёсыг номлосон, ялгасны шашин эрдэнийг тодруулагч зул” (1819), Ишбалдангийн “Эрдэнийн эрих” (1835), Дармадалайгийн “Цагаан лянхуан эрхис” (1889), Зава Дамдины “Алтан дэвтэр” (XX зууны эхэн), ... зэрэг төвд хэлний, “Юань улсын түүх” (1369), “Юаний үеийн зураг сонгомолын тэмдэглэл”, ... зэрэг хятад хэлээр зохиогдсон түүхэн сурвалж бичгүүдэд их бага ямар нэг хэмжээгээр өгүүлжээ. Тухайлбал, Лувсанданзаны “Алтан товч”, Жамбын “Асрагч нэртийн түүх” зэрэг зохиолд “Хүлэг хааны лам нь Чойжи-Одсэр”<sup>2</sup> хэмээн цухас өгүүлсэн байхад Саган Сэцэний “Эрдэнийн товч”-д “Тэндээс Дармабалын хөвүүн Хүлэг хаан могой жилтэй хорин наймны бичин жил хаан сууж тойн Чойжи-Одсэр Номын гэрэл хэмээх хэлмэрчээр судар тарнийн хамаг номны ихэнхийг орчуулуулаад хоёр төрөөр хотлыг тэжээгээд дөрвөн жил хааны төрийг барин гучин нэгнийхээ (син) гахай жил халив”<sup>3</sup>, “Йин Зүн хааны жи жи-гийн анхан он (1321)-ы ... дөрөвдүгээр сард,

<sup>1</sup> Доктор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

<sup>2</sup> Лувсанданзан *Алтан товч*. Хэвлэлд бэлтгэсэн Ц. Шагдар. Уб., 1957. 165 дугаар тал  
Жамба *Асрагч нэртийн түүх*. Monumenta Historica., Том II. Fasc 4. Уб., 1960. 44 дүгээр тал

<sup>3</sup> Саган Сэцэн *Эрдэнийн товч*. Monumenta Historica., Том I. Fasc 1. Уб., 1960. 143 дугаар тал

зарлиг гаргаж Чойжи-Одсэр багшийн сүмийг байнгын цэрэг таван хүнээр сахин хамгаалах болгов”<sup>4</sup> гэх зэргээр өгүүлсэн байна.

Дээрх түүхэн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэн үлдсэн Чойжи-Одсэрийн тухай мэдээ баримтыг ерөнхийлөн нэгтгэж авч үзвэл монгол, төвд хэлээр бичсэн сурвалжуудад нэлээд товч, анх нэг эхээс авсан болов уу гэмээр утга агуулга ойролцоо мэдээллүүд байгаа бол хятад хэлээр бичигдсэн эхүүдэд харьцангуй өөр өөр олон янзын агуулгатай мэдээллүүд оржээ.

Харьцангуй эрт үеийн, тэр тусмаа монголын хэлбичиг, соёл урлаг, уран зохиол, гүн ухааны зэрэг олон салбарыг төлөөлөхүйц нэрт соён гэгээрүүлэгч, эрдэмтэн зохиолчийн хувьд Чойжи-Одсэрийг үе үеийн олон эрдэмтэн судлаачид, эрдэмтэн Ц. Дамдинсүрэнгийн “Чойжи-Одсэр бол монголын хэлбичгийн эрхэм зүтгэлтэн байсан тул түүний бүтээл бүрийг бид сонирхон судлах хэрэгтэй”<sup>5</sup> гэж хэлсэнчлэн тал талаас нь судлан шинжилж, өдгөө “Чойжи-Одсэр судлал”-ыг нэгэнт үүсгэсэн байна. “Чойжи-Одсэрийн зохиол бүтээлүүдийг орчуулах, хэвлүүлэх, судлах ажил Юань улсын Есөн Төмөр хаан (1323-1328)-ы үе буюу цаашилбал Есөн Төмөрийн хаан суухын өмнөх хэдэн жилээс эхлээд одоо болтол 600 гаруй жил үргэлжилж байна.”<sup>6</sup> Тэр дундаа Чойжи-Одсэр судлал өнгөрсөн зуунаас нэлээд эрчимтэй, шинжлэх ухааны үндэслэл сайтай болж ирсэн гэж хэлж болно. 600 гаруй жил үргэлжилсэн Чойжи-Одсэр судлалаар манай нэрт эрдэмтэн Ц. Дамдинсүрэн<sup>7</sup>, Д. Цэрэнсодном<sup>8</sup>, Т. Пагва<sup>9</sup>, Б. Ринчен<sup>10</sup>, Ч. Жүгдэр<sup>11</sup>, Ш. Бира<sup>12</sup>, Ш. Лувсанвандан<sup>13</sup>, Ж. Надмид<sup>14</sup>, Д. Төмөртоогоо<sup>15</sup>, Ё. Жанчив<sup>16</sup>, гадаадын монголч эрдэмтдээс зөвлөлтийн /хуучин нэрээр/ Б. Владимирцов<sup>17</sup>, Ю. Н. Рерих<sup>18</sup>, А. Позднеев<sup>19</sup>, францын П. Пеллио<sup>20</sup>, германы Ф. Веллер<sup>21</sup>, Э. Хэниш<sup>22</sup>, америкийн В.

<sup>4</sup> Kesigtoyaqu С. *Mongyol-un erten-ü udq-a jokiyal-un sin-e sudulul*. Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a., 1999. 524 дүгээр талаас дам авав.

<sup>5</sup> Дамдинсүрэн Ц. *Монголын уран зохиолын тойм*. Хоёр дахь хэвлэл. Уб., 1999. 135 дугаар тал

<sup>6</sup> Kesigtoyaqu С. *Mongyol-un erten-ü udq-a jokiyal-un sin-e sudulul*. Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a., 1999. 517 дугаар тал

<sup>7</sup> Дамдинсүрэн Ц. *XIV зууны үеийн монгол хэл бичгийн эрдэмтэн Чойжи-Одсэр*. ШУ-ны хүрээлэнгийн бүтээл. №2, Уб., 1957, *Монголын уран зохиолын тойм*. Хоёр дахь хэвлэл, Уб., 1999. 132-157 дугаар тал

<sup>8</sup> Цэрэнсодном Д. *Об одном стихотворении из Турфанского сборника*. Доклады монгольской делегации на XXVI конгрессе Востоковедов. Уб., 1963. 9-12 дугаар тал, *Турфаны цуглуулгын ТМ /5/ D 130*. *Studia Mongolica*. Tom VII., Fasc 3. Уб., 1969, *XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр*. Уб., 1969, *Монголын уран зохиолын товч түүх*. (XIII-XX зууны эхэн) Уб., 2002. 202-221 дүгээр тал

<sup>9</sup> Пагва Т. *Зүрхний тольтын тайлбарыг судалсан тухай тэмдэглэл*. Уб., 1957

<sup>10</sup> Ринчен Б. *Монгол бичгийн хэлний зүй*. Тэргүүн дэвтэр. Уб., 1964

<sup>11</sup> Жүгдэр Ч. *Развитие философской мысли Монголии в XIX веке*. М., 1964

<sup>12</sup> Бира Ш. *Шагдарын Дамдины “Алтан дэвтэр” гэдэг номын тухай*. ШУ сэтгүүл. Уб., 1960. №6

<sup>13</sup> Лувсанвандан Ш. *Орчин цагийн монгол хэлний зүй*. Тэргүүн дэвтэр. Уб., 1967

<sup>14</sup> Надмид Ж. *Монгол хэл түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм*. Уб., 1967

<sup>15</sup> Төмөртоогоо Д. *Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд*. Уб., 2002. 323-341 дүгээр тал

<sup>16</sup> Жанчив Ё. *Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд*. Уб., 2005. 54-56, 169-196 дүгээр тал

<sup>17</sup> Владимирцов Б. *Монгольская литература*. Литература Востока. вып. 2, СПб., 1920. стр. 90-115, *Bodhicaryāvatāra Cāntideva* Монгольский перевод Chos-kyi Hod-zer'a. Л., 1929

<sup>18</sup> Roerich G.N. *Kün-mkyen chos-kyi hod-zer and the origin of the Mongol alphabet*. Journal of the Royal Asiatic Society of Bengal., 1945. vol XI. pp. 52-58, *Монголо-Тибетские отношения в XIII-XIV вв.* Филология и история монгольских народов. М., 1958. стр. 333-346

<sup>19</sup> Позднеев А. М. *Лекции по истории монгольской литературы*. СПб., 1896. стр. 124-139

Кливез<sup>23</sup>, мажарын Л. Лигети<sup>24</sup>, хятадын Ч. Хишигтогтох<sup>25</sup>, Гарди<sup>26</sup>, ... нар амжилттай ажиллаж, тодорхой үр дүн шийдлүүдэд хүрсэн байна. Чойжи-Одсэрийн тухай өгүүлсэн түүхэн сурвалжуудын мэдээ баримт, судлаачдын хийсэн судалгаа шинжилгээний үр дүнг нэгтгэн авч үзвэл:

1. Чойжи-Одсэр XIV зууны эхний хагас буюу Хайсан Хүлэг (1307-1311), Буянт (1311-1320) зэрэг хааны төр барьж байх үед ажиллаж амьдарч, уран бүтээлээ туурвиж байжээ.
2. Чойжи-Одсэр монгол, төвд, санскрит зэрэг хэлийг төгс эзэмшсэний хувиар бурхны шашны холбогдол бүхий “судар тарнийн хамаг номуудыг монголоор орчуулсан”<sup>27</sup> хэмээн түүхэн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдсэн байдаг ч бидний үед түүний 1305 оны үед орчуулсан эртний Энэтхэгийн эрдэмтэн Шантидевагийн “Бодичария аватара” (са. Bodhiçaryāvātāra, тө. Byang chub sems-pa’i ‘jod-ba la ‘jug-ba, мо. Бодь мөрийн явалд орохуй) хэмээх гүн ухааны яруу найргийн 10 бүлэг 913 бадаг буюу 3652 шад орчим шүлэг уламжлан иржээ. Уг орчуулгын анхны эх одоогоор олдоогүй байгаа зэргээс үүдэн судлаачид ямар хэлнээс Чойжи-Одсэр орчуулсан тухайд нэг хэсэг нь уг зохиолын монгол эхийн хэл найруулгын онцлог, орчуулгын дууны болон чиг орчуулгын зарчмыг харгалзан төвд хэлнээс орчуулсан гэж үздэг ч нөгөө хэсэг нь монгол Данжуурын 114 дүгээр ботийн эхэнд хэвлэгдсэн “Бодичария аватара”-ийн орчуулгын төгсгөлийн “Энэ мэт орчуулсан төвдийн хэлнээс монголын хэлээр урьд ном үгүйн тул өдий төдий аялгуугаар энэтхэгээс би Чойжи-Одсэр аяга тэхимлэг энэ ба номыг бусад бар судар шастир номын тайлбар давтан сонсож бэлгэтэйгээ төдий ухааж оносны шадтгаанаар эсрэг тэмцэлдэн асуусан аюул үгүй хариу өгүүлэхүй билиг олсондоон дулдуйдаж могой жшилд орчуулав” гэсэн мэдээнд тулгуурлаж энэтхэг хэлнээс орчуулсан гэж үздэг. Бидний бодлоор Чойжи-Одсэр аль ч хэлэн дээрх эхийг барилаа гэсэн бусад хэлэн дээрх эхийг харгалзан үзэж, тулган хянаж орчуулсан биз. Тийм ч учраас энэтхэг, төвд хэлний аль аль эхээс орчуулсан байж болохоор

<sup>20</sup> Pelliot P. *Sur quelques mots d'Asie Centrale attestés dans les textes chinois*, JA, Onzième série., 1913. pp. 451-463, *Les systèmes d'écriture en usage chez les anciens Mongols*. AM., 1925, 2, pp. 284-289

<sup>21</sup> Weller F. *Zum Blockdruck fragmente des Mongolischen Bodicyāvatāra der Berliner Turfansammlung*. (ADAWB.KSLK Jahrgang 1954. №2) Berlin., 1955, *Zum Mongolischen Tanjur, Berichte über die Verhandlungen der Sächsischen Akademie der Wissenschaften zu Leipzig, Philologische-historische Klasse Band 97.*, 1949, *Zum Blockdruckfragmente des Mongolischen Bodicyāvatāra der Berliner Turfansammlung, Abhandlungen der Deutschen Akademie der Wissenschaften zu Berlin. Klasse für Sprachen, Literatur und Kunst Jahrgang.*, 1954

<sup>22</sup> Haenisch E. *Mongolica der Berliner Turfan-Sammlung*. II. Mongolische Texte der Berliner Turfan-Sammlung in Faksimile. Berlin., 1959

<sup>23</sup> Cleaves F. W. *The Bodistw-a Čari-a Awatar-un Tayilbur of 1312 by Čosgi Odser*. HJAS.vol 17. №1., 1954. pp.1-129

<sup>24</sup> Ligeti L. *A propos de la version mongole des "Douze actes du Bouddha"*. Acta Orient. Hung. Tom XX., 1967. pp. 59-73

<sup>25</sup> Kesigtoytaqu Č. *Mongyol-un erten-ü udq-a jokiyal-un sin-e sudulul*. Óbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a., 1999. 516-543 дугаар тал

<sup>26</sup> Гарди. *Turfan-ača oldaysan "Dörben muturtu Maqakali-yin maytayal" kiged tegün-dü qolbuydaqu jarim asayudal*. ÖMYSESB., 1996. №4., 17-29, *Dörben muturtu Maqakali-yin ungsily-a üsüglet kiged seyireg üül tayilburi*. ÖMYSESB., 1997. №3., 1-15

<sup>27</sup> Цэрэнсодном Д. *XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр*. Уб., 1969. 44 дүгээр тал

ажиглагддаг байж болно. Ямар хэлнээс орчуулсан байлаа ч ном эрдэм сурч сэтгэлээ ариусгаад амьтанд хүргэж болох бүх тусыг хүргээд бурхан болох замыг заасан эртний Энэтхэгийн гүн ухааны сонгодог яруу найргийг орчуулсан нь л нэн ач тустай зүйл билээ. Мөн Чойжи-Одсэрийг судалсан олонх судлаачид уншин шүлэглэгч хэн бүхний аливаа цаг бусын хор хөнөөл, гай зовлонг зайлуулан сайн сайхан, эрүүл энх байлгаж, өглөгийн эзний үүд хаалгыг нээн эрдэм билиг, эд хөрөнгө тэргүүтнийг хүртээх чадалтай хэмээгддэг Банзрагч (са. Pañcaraksā, мо. Таван сахъяа) судрыг монгол хэлнээ орчуулсан гэж үздэг ч, уг орчуулгын төгсгөлийн үгэнд:

*inen uduriduyči ögülegčid-ün naran  
uĉaraju ĉosgi odser neretü kelemürči-lüge  
üy-e qoyar-un ary-a bilig-ün küĉün-iyer*

*our mongyol-un ayalyu-bar nom-i delgeregüljük-ii* хэмээн өгүүлжээ. Энд *inen uduriduyči ögülegčid* буюу ном өгүүлэгчид гэж Хайсан Хүлэг хааныг хэлсэн бололтой. Иймд Чойжи-Одсэр хэрвээ уг зохиолыг орчуулж, төгсгөлийн үг бичсэн бол эхэс дээдсээ хүндэтгэх, хүндлүүлэх монгол ёс заншилыг нэвтэрхий мэддэг их бичгийн эрдэмтэн хүний хувьд өөрийгөө *üy-e qoyar-un ary-a bilig-ün küĉün-iyer* хэмээн хаантайгаа зэрэгцүүлэн нэг зиндаанд аваачихгүй биз. Харин өөр хүн уг зохиолыг орчуулж, төгсгөлийн үг бичихдээ Хайсан Хүлэг хааны зарлигаар уг бүтээлийг орчуулж, Чойжи-Одсэр эрдэмтний боловсруулсан хэл зүй, холбон шүлэглэх дэг жаягийн дагуу монгол хэлэнд буулгасан тухайгаа илэрхийлсэн гэж ойлгож байна.

Мажарын монголч эрдэмтэн Л. Лигети “Банзрагчийн монгол орчуулгыг Чойжи-Одсэрийн уран бүтээлээс хасах хэрэгтэй”<sup>28</sup> хэмээн өгүүлсэн бол монголч эрдэмтэн К. Сагастер мөн Чойжи-Одсэр Банзрагчийг анх орчуулсан гэдгийг үгүйсгэн “Банзрагчийг харин анх Шаравсэнгэ орчуулсан байж болно”<sup>29</sup> гэсэн таамаглалыг дэвшүүлсэн байна.

3. Чойжи-Одсэр нь бидэнд мэдэгдэж байгаагаар Улсын багш<sup>30</sup>, Бандида<sup>31</sup>, Хагархайяа<sup>32</sup>, Аяга тэхимлэг<sup>33</sup>, Хэлмэрч<sup>34</sup>, Агам ёгточ<sup>35</sup>, Дархан лам<sup>36</sup> гэх зэрэг алдар цолтой нэгэн байжээ.

<sup>28</sup> Ligeti L. *A propos de la version mongole des “Douzes actes du Bouddha”*. Acta Orient. Hung. Tom XX., 1967. p.62

<sup>29</sup> Sagaster K. *Hat Ćos kyi odser die Pañcaraksa ins mongolische üdersetzt?*. Олон улсын монголч эрдэмтний II их хурал. Боть II. Уб., 1973. 85-96 дугаар тал

<sup>30</sup> *Юань улсын судар*. 24-р дэвтэр 42-р тал. (Мин улсын хаан Жу Юань Жаны 1368 онд гаргасан зарлигийн дагуу Сун Лянь, Ван Вэй нарын удирдсан хятадын 30 гаруй бичгийн түшмэл 1369 оноос эхлэн бичээд дунд нь нэг удаа түр завсарлаад 331 хоног бичиж дуусгасан зохиол. Сударт Чингис хаанаас хойших 165 жилийн түүхийг бичжээ. Уг зохиолыг монгол хэлнээ Ч. Дэмчигдорж /1863-1932/ 1917 оноос орчуулж эхлээд 1920-1923 оны хооронд түр завсарлаад 1925 онд хөрвүүлж дуусгасан түүхтэй. Энэ орчуулгын 210 дэвтэр гар бичмэл өдгөө УННС-д хадаглагдаж буй.) Үгийн утга нь: төрийг дотороос нь буюу номын үүднээс нь засагч

<sup>31</sup> *Монгол Данжуур*. 108-р боть. 20-р талд. Үгийн утга нь: Учир шалтгааны ухаан, дуун ухаан, тэжээхүй ухаан, урлахуй ухаан, дотоод ухаан гэсэн их таван ухааны номд нэвтэрхий мэргэшсэн хүнийг нэрлэдэг цол.

<sup>32</sup> “*Дөрвөн мутарт Махагалийн магтаал*” шүлгийнхээ 2 дугаар мөрд өөрөө өөрийгөө ингэж тодорхойлсон. Үгийн утга нь: яруу тодорхой.

<sup>33</sup> *Bodhicaryāvatāra-yin tayilburi*-ийн төгсгөлд. Үгийн утга нь: эрхэм, хүндтэй, чухал

4. Чойжи-Одсэр нь монгол хүний оюун сэтгэлгээний мөн чанарт суурилсан монгол хэлний өвөрмөц зүй тогтлыг сайтар тусгасан “Зүрхэн толг” хэмээх хэл зүйн зохиол туурвиж, энэхүү хэл зүйнхээ дагуу энэтхэг, төвд зэрэг хэлнээс олон зохиол бүтээл орчуулан найруулахын үлгэр жишээг үзүүлсэн нь монгол хэлнээ гадны зохиол бүтээлийг орчуулахад баримтлах дэг журам, монгол хэлний уран яруу холбон найруулах хэм хэмжээг сайжруулснаараа дундад эртний монголын бичгийн хэлний зүй тогтлыг бүрдүүлэх үйлст жинтэй хувь нэмэр оруулсан байна.
5. Бандида Чойжи-Одсэр бурхны шашны хөлгөн их судруудыг монгол хэлнээ хөрвүүлж байсны зэрэгцээ энэтхэг, төвд зэрэг дорно дахины орны мэргэдийн ном зохиолынхоо үүдэл санаа, гол агуулга, хаана, хэзээ, хэний зарлиг шийдвэр, тусламжаар зохиосон зэрэг мэдээллийг өгүүлдэг эхлэл, төгсгөлийн шүлгийн уламжлалыг монголын уран зохиолд бүтээлчээр нэвтрүүлжээ.

Энэ бүхнээс авч үзвэл өмнө нэр дурдсан түүхэн сурвалжууд дахь мэдээ баримтад тулгуурлан Чойжи-Одсэрийн намтар түүхийг тодруулан, уламжилж ирсэн бүтээл туурвилыг нь эх бичиг сурвалж судлал, хэл найруулга талаас нь ихэвчлэн судалжээ.

Чойжи-Одсэрийн зохиол бүтээлүүд шууд уламжилж ирсний хувьд XIV зууны үеийн монголын хэл соёл, зан заншил, ахуй сэтгэлгээ, шүлэг найргийн олон онцлогийг тэндээс олж харах боломжтой. Судлаачид энэ асуудал руу анхаарлаа хандуулсаар ирсэн ч шүлэг найргийнх нь мөн чанар, уран сайхны талыг дагнан судалсан нь эрдэмтэн Д. Цэрэнсодномын “XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр” (Уб., 1969) бүтээлийг эс тооцвол тун цөөн байна. Энэ бүхнээс үүдэн бид энэ удаад Чойжи-Одсэрийн уран бүтээлээс харьцангуй бүрэн эхээрээ уламжлагдаж ирсэн, уран сайхны хувьд бусад бүтээлээсээ сайн болсон “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгийг нь нарийвчлан авч үзэж, уг шүлгийн болоод XIV зууны үеийн монгол шүлгийн ерөнхий онцлог тогтолцоог тодруулахад анхаарлаа хандуулж байгаа билээ. Уг шүлгийн тухай авч үзэхийн өмнө Махагали бурхны тухай товч өгүүлье.

Махагали гэдэг нэр бол санскрит хэлний Mahākala буюу Mahākali-ийн авиачилсан бичлэг юм. Төвдөөр Lhamo (Лхам), монголоор “Их хар охин”, “Их хар тэнгэр”, “Их хар охин тэнгэр”, “Төгс цогт охин тэнгэр”, “Их хар эх” гэх зэргээр орчуулан нэрлэсэн байна.

1073 оны үед төвдийн Зана мужийн Сажа (Sa-skya), монголоор “Цайвар шороот” хэмээх газар буддын шашны нэртэй зүтгэлтэн лам Гончигжалцан (1034-1102) буддын шашны нэгэн шинэ дэг урсгал үүсгэсэн түүхтэй. Энэ урсгалыг буддын шашны түүхэнд сажа урсгал, сажийн ёс гэх зэргээр нэрлэж иржээ. Энэ урсгал бидний өнөөдрийн ойлгодог буддын шашны улааны урсгал юм. Энэ сажа урсгалынхан бурхны шашны хөгжил хувьсалд жинтэй хувь нэмэр оруулсан гэж үзэх үндэстэй. Учир нь энэ урсгалын лам нараас бидний өгүүлэн буй Чойжи-Одсэр, Шаравсэнгэ, Гунгаажалцан, Лодойжалцан ... тэргүүтэй эрдэмтэн мэргэд төрөн гарчээ. Тэр ч утгаараа энэ урсгалын

<sup>34</sup> Саган Сэцэн. *Эрдэнийн товч*. Уб., 1960. 143 дугаар тал. Үгийн утга нь: дуун хөрвүүлэгч буюу орчуулагч

<sup>35</sup> *Bodhicaryāvatāra-yin tayilburi*-ийн төгсгөлд. Үгийн утга нь: агама гэдэг үг нь дуун ухааны ном, югти буюу ёгт нь далд битүү гэсэн утгатай. Нийлээд утга далдлан шүлэглэгч гэсэн үг.

<sup>36</sup> *Монгол Данжуур*. 70, 82 дугаар боть. Үгийн утга нь: Эрх нь дархлагдсан буюу хэнээс ч хараат бус гэсэн утгатай.

лам нарыг сажа Чойжи-Одсэр, сажа бандида Гунгаажалцан гэх зэргээр түүхэнд тэмдэглэн үлдээжээ.

Бурхны шашны сажийн урсгалын гол шүтээнүүдийн нэг нь бидний өгүүлэн буй Махагали бурхан юм. Махагали бурхны эрдэм билиг, хүч чадал, даан хариуцдаг зүйлийн тухай “Бэлгэ, билгийн итгэл, шашныг сахигч хамаг номын сахиул”<sup>37</sup>, “Номыг тэтгэгч шашны сахиул. Бурхны шашныг сахих аугаа хүчтэн. Их Цогт бодит хувилгаан бэлгэ билгийн Махагали”<sup>38</sup>, “Цогт их хар Очир Гүр Махагали. Цогт итгэл Махагали”<sup>39</sup> гэхчлэн судар шастирт өгүүлсэн байна. Эндээс үзвэл эрдэм билиг, ном шүтээнийг сахин дэлгэрүүлэгч бурхан бол Махагали болох нь харагдаж байна. Мөн Махагалийг амармагын орны эрхин төгс тангарагт дөрвөн догшин бурхны нэг<sup>40</sup> ч гэж нэрлэх ёсон бий.

Махагали бурхан дотроо олон янз байдгийг ихэвчлэн мутрын тоо, өнгөөр нь ялган өгүүлсэн байдаг. Тухайлбал, эрдэмтэн Чойжи Германы Бонны их сургуулиас сэргээн хэвлүүлсэн 1431 онд Бээжинд анх барласан модон барын нэгэн эхэд Махагали бурхны тухай “Хоёр гарт, дөрвөн гарт, зургаан гарт гэх гурван ялгалаар нэрлээд тус тус хөрөг дүр, тарнийг бичиж тэмдэглэжээ”<sup>41</sup> гэж өгүүлсэн байхад “Цогт Махагали их бага үйлчнүүдийн билгийн зан үйл дөрвөн үйлс жавхлантайяа бүрдсэн оршвой” сударт “Хөхөмдөг хар өнгө, баярт нэгэн нүүр, хоёр гарт. Хөхөмдөг хар өнгө, баярт нэгэн нүүр, дөрвөн гарт. Хар өнгөт нэгэн нүүр, хоёр гарт. Хар өнгөт баярт дөрвөн нүүр, дөрвөн гарт”<sup>42</sup> хэмээн өгүүлсэн байна. Тэгвэл “Шашны сахиулсан бүрэн төгссөний үйлс оршив” сударт “Хүрэн хар өнгөт нэгэн нүүр, хоёр гарт”<sup>43</sup> гэх мэтээр өгүүлсэн байна. Тэгвэл Данжуурын тарнийн аймаг дахь “Цогт хар охин тэнгэрийн магтаал” хэмээгдэх сударт “Баруун гартцаа бадрангуй илд барьсан нь тангараг буурсан дайсан тотгорын амин судсыг огтлохын тэмдэг. Хоёрдугаараар улаан их уйтан гавал барьсан нь гурван сансрын мах цусыг амандаа өрөвхийхийн тэмдэг. Зүүнээр хурц жад дор оронго дэлгэсэн нь тангараг буурсныг хоцрол үгүй угаас огтлохын тэмдэг. Хоёрдугаараар гурван салаат сэрээ барьсан нь гурван орны нисванисыг тоос болгон сүйтгэхийн тэмдэг”<sup>44</sup>, мөн Норовшаравын “Зуун бурхны бүтээлийн арга” хэмээх зохиолын 237, 241 дүгээр хуудсанд Цогт Дудсолмар болон дөрвөн мутарт Цогт Лхамо хоёрыг магтсан хэсэгт “Өнгө нь хар, нэгэн нүүр, дөрвөн мутартай, хоёр хөлт. Баруун дээддээ илд, дооддоо улаан цустныг /гавал/ барьсан. Зүүн дээддээ шагди, дооддоо торгон унжлагат

<sup>37</sup> Jokiyaγci ni ülü medegdekü “*Takil-un sang orusiba*”, qulusun üjüg-ün bičimel sudur (Öbür Mongγol-un baγsi-yin yeke surγayuli-yin nom-un sang) 2b

<sup>38</sup> Lubsangjamso “*Čoytu maqakala yeke bay-a üleči-nügüld-ün baling-un jang üile dörben üiles jibqulangtay-a bitügsen orusiba*”, qulusun üjüg-ün bičimel sudur (Öbür Mongγol-un baγsi-yin yeke surγayuli-yin nom-un sang) 4a ba b, 5a ba b.

<sup>39</sup> Garudi. *Turfan-ača oldaysan “Dörben muturtu Maqakali-yin maytayal” kiged tegün-dü qolbuydaqu jarim asaγudal*. ÖMYSESB., 1996. №4., 19 дүгээр тал

<sup>40</sup> Jokiyaγci ni ülü medegdekü “*Dörben doysin-u baling*”, qulusun üjüg-ün bičimel sudur (Öbür Mongγol-un baγsi-yin yeke surγayuli-yin nom-un sang)

<sup>41</sup> Чойжи “1431 оны нэгэн иж үйгаржин бичгийн модон барын судар” Монгол хэл, утга зохиол. 1990. №4 75-80 дугаар тал

<sup>42</sup> Lubsangjamso “*Čoytu maqakala yeke bay-a üleči-nügüld-ün baling-un jang üile dörben üiles jibqulangtay-a bitügsen orusiba*”, qulusun üjüg-ün bičimel sudur (Öbür Mongγol-un baγsi-yin yeke surγayuli-yin nom-un sang) 4a ba b, 5a ba b.

<sup>43</sup> Olan kelemürčid-un orčiγuly-a “*Šasin-u sakiγulsan burin tegüsügsen-ü üiles orusiba*”, qulusun üjüg-ün bičimel iji sudur-ud (Öbür mongγol-un baγsi-yin yeke surγayuli-yin nom-un sang)-tu lablamu

<sup>44</sup> Цэрэнсодном Д. XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр. Уб. 1969., 95 дугаар тал

дришүла барьж хүний хүүр амандаа зуусан. Соёо нь ярзайсан, гурван улаан нүдтэй. Улаан шаргал үс нь өрвийн зүүн тийш мушгирсан. Баруун чихэндээ хонхон хүзүүн чимэгт могой, зүүндээ арслан зүүсэн. Цэцэг хийгээд хар өнгөт титимтэй. Зааны арьсан цамцтай. Үхрийн арьс болон шар хэвнэгээр бөгсөө ороосон Лусын хаан /могой/ хослуулсан бүстэй. Төмөр чөдрөн чимэгт хөлөөрөө халзан илжсэн дээр альбангийн завлилаар суусан”<sup>45</sup> гэх мэтээр өгүүлсэн байна. Энэ бүхнээс үзвэл харилцан адилгүй цаг үед бурхны шашинтай өөр өөр улс үндэстнүүд олон янзын Махагалийг бүтээн залж байсан түүх, түүнтэй холбоотой соёл зан үйлүүдийн олон асуудлуудыг Чойжи-Одсэр харьцуулан судлан шинжилж үзээд дөрвөн мутарт Махагалийг монгол газар, монгол хүний сэтгэлгээ сүсэг бишрэлд идээшин дассан дөрвөн мутарт Махагали бурхны онцлогийг гадаад, дотоод мөн чанараас хөрөглөн дэлгэрэнгүй дүрслэн шүлэглэсэн байна. Энэ утгаараа бурхны шашны судар дандарт тэмдэглэсэн Махагалийн тухай өгүүлэмжүүдийг судлаачид Чойжи-Одсэрийн магтаал шүлэгтэй харьцуулан судлаад “Чойжи-Одсэрийн зохиосон Махагали бурхнаас дэлгэрэнгүй өгүүлсэн магтаал бидэнд огт дайралдахгүй байна”<sup>46</sup>, “Ярилцаж байгаа энэ магтаал маньд олдсон аль ч судрынхаас илүү нарийн тодорхой болсон байдаг”<sup>47</sup> гэж онцлон тэмдэглэсэнчлэн бурхны шашны судар шастирт тэмдэглэгдэн үлдсэн ямар ч Махагалиудаас Чойжи-Одсэрийн шүлэглэл өргөн дэлгэр утга агуулган дээр яруу найргийн үүднээс бичсэний хувьд хавьгүй илүү уран сайхантай болсон ажээ. Энэ бүхнээс үндэслээд Чойжи-Одсэрийн уг шүлгийн нэрийг эрдэмтэн судлаач Д. Цэрэнсодном багшийн нэрлэсэн “Махагалийн магтаал” гэж нэрлэснийг дэлгэрүүлэн тодруулж “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” хэмээн судлаач эрдэмтэн Гардийн нэрлэснийг бид дагаж байгаа болно. Ер нь ижил өнгө зүс, ижил мутартай Махагалиуд дотоод мөн чанараараа харилцан адилгүй байгааг судлаач эрдэмтэн Гарди<sup>48</sup> ажиглаж тэмдэглэсэн нь санамсаргүй зүйл биш бололтой байна. Энэ бүхэн угтаа бол харилцан өөр цаг үе, өөр сүм хийд, өөр лам нарын шүтлэг бишрэлээс болсон хэрэг.

Монголчууд Махагали бурхныг ихэд хүндэтгэн шүтэж, биширч байсныг Хубилай хааны үед Дайду хотноо Махагали бурхныг алтаар бүтээж, гэрэлт цагаан суваргат сүмд тусгай дуган барин залж, тэндээ шашны номыг монголоор хурж байсан мэдээ батална. Өдгөө ч Махагали бурхны нөлөө монголд хэвээр байна

Одоо “Дөрвөн мутарт Махагали бурхны магтаал” шүлгийн тухай авч үзье. 1902-1904 онд Германы эрдэм шинжилгээний анги дорнод Туркестаны Турфан хэмээх газар, тэр дундаа эртний Уйгур улсын томоохон хот байсан Хар Хожо гэдэг балгасны суурийн малтлагаас уйгур, монгол, төвд, санскрит зэрэг бичгийн олон тооны дурсгал олж, Берлин хотноо аваачиж, ШУА-ийнхаа эртний түүх археологийн төв хүрээлэнгийн номын санд хадгалжээ. Эдгээр олдворыг шинжлэх ухаанд “Турфаны цуглуулга” (Turfan Collection) гэж нэрлэж заншсан байна.

Турфаны цуглуулгын дунд монголын уран зохиолын нэгэн дурсгал болох Чойжи-Одсэрийн “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлэг байсныг Германы монголч эрдэмтэн Э. Хэниш “Mongolica der Berliner Turfan-Sammlung” II (Berlin. 1959) гэх

<sup>45</sup> Цэрэнсодном Д. XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр. Уб. 1969., 92 дугаар тал

<sup>46</sup> Цэрэнсодном Д. XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр. Уб. 1969., 92 дугаар тал

<sup>47</sup> Garudi. Turfan-ača oldaysan “Dörben muturtu Maqakali-yin maytayal” kiged tegün-dü qolbuydaqu jarim asayudal. ÖMYSESB., 1996. №4., 21 дүгээр тал

<sup>48</sup> Garudi. Turfan-ača oldaysan “Dörben muturtu Maqakali-yin maytayal” kiged tegün-dü qolbuydaqu jarim asayudal. ÖMYSESB., 1996. №4., 20 дугаар тал

номынхоо ТМ 3D 130 (p11), ТМ 6D 130 (А6а, А6б-р14-15), ТМ 2D 130 (p10) гэх талд дөрвөн тасархай хуудас гэрэл зургаар хэвлэсэн байдаг. Энэ дөрвөн хуудсанд хэвлэгдсэн шүлгийг шадын тоогоор нь авч үзвэл:

ТМ 3D 130-20 шад

ТМ 6D 130 (А6а, А6б)-40 шад

ТМ 2D 130 (арын нугалбар)-5 шад

ТМ 2D 130 (өмнөх нугалбар)-3 шад байна. Энэ нь нийт 68 шад шүлэг юм. Уг гэрэл зургаар хэвлүүлсэн шүлгийн эхийг эрдэмтэн Д. Цэрэнсодном дагнан судлаад<sup>49</sup> XIV зууны үеийн монголын нэрт бичгийн хүн Чойжи-Одсэрийн бүтээл болохыг баталж, шүлгийн дэс дарааг тогтоон, шүлгийн нэрийг шүлгийн агуулгад тулгуурлан “Махагалийн магтаал” хэмээн нэрлэж, зарим дутуу үгийг сэргээн сийрүүлж, галиг үсгээр хэвлүүлсэн байна. Дараа нь өвөрмонголын монголч эрдэмтэн Гарди уг шүлгийг тусгайлан авч судлаад<sup>50</sup>, монгол бичгээр сийрүүлж, латинаар галиглан хэвлүүлэхдээ шүлгийн нэрийг илүү тодруулж “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” хэмээн нэрлэсэн тухай дээр өгүүлсэн билээ.

“Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгийн уран сайхны асуудлыг доорх хэдэн зүйлээр авч үзэв.

### “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгийн бүтэц зохиомж, агуулга

“Дөрвөн мутарт Махагалийн магтаал” нь бүтэц зохиомжийн хувьд гурван хэсгээс бүрдсэн, тус бүрдээ бие даасан агуулгатай шүлэг байна.

Эхний хэсэг нь уг шүлгийн эхлэл буюу тахилын үг юм. Энэ нь зохиолын эхний бадаг болох: (Хойшид бадаг бүрийн дугаарыг өмнө нь, шад бүрийн үеийн болоод үгийн тоог ард нь өгүүлэн буй дэс дарааллын дагуу тэмдэглэв. Мөн бадгийн ерөнхий дугаарыг бадаг бүрийн мөрийн эцэст тэмдэглэв.)

1. .... Бадаг 1

qamuy-a yauiqayuluysan erdem-i činu ss (14) (3)  
qayaraqai-a qolban maytasuyai v (11) (3) гэсэн мөрүүд болно.

Уг хэсэг эхнээсээ дутуу уламжилж иржээ. Хамгийн багаар бодоход 4 шад буюу 1 бадаг, цаашлаад 8 шад 2 бадаг, 12 шад 3 бадаг, 16 мөр 4 бадаг байсан байх. Ер нь бол бурхан шашны холбогдол бүхий магтаал дууллын тахил үг ихэвчлэн 2 бадаг 8 мөр орчим шүлэг байдаг уламжлалтай.

Энэ хэсгийн агуулга нь дөрвөн мутарт Махагали бурхныг бүх талаас нь зохиолч хамаг байдаг авьяас билиг, эрдэм чадлаараа уран яруу холбон найруулж магтя гэсэн ерөнхий зорилгоо өгүүлжээ.

<sup>49</sup> Цэрэнсодном Д. *Об одном стихотворении из Турфанского сборника*. Доклады монгольской делегации на XXVI конгрессе Востоковедов. Уб., 1963, *Турфаны цуглуулгын ТМ /5/ D 130*. Studia Mongolica. Tom VII., Fasc 3. Уб., 1969, XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр. Уб., 1969

<sup>50</sup> Garudi. *Turfan-ača oldaysan “Dörben muturtu Maqakali-yin maytayal” kiged tegün-dü qolbuydaqu jarim asayudal*. ÖMYSESB., 1996. №4, *Dörben muturtu Maqakali-yin ungsily-a üsüglel kiged seyiregüil tayilburi*. ÖMYSESB., 1997. №3



Хоёрдугаар хэсэг нь уг зохиолын гол өрнөл хэсэг буюу дөрвөн мутарт Махагали бурхныг магтан дуулсан шүлэглэл юм. Зохиомжийн хувьд дотроо 2 хэсэгтэй буюу эхний 8 бадаг нь:

1. dörben γar-tai nigen niγur-tai ss	(9)	(4)	Бадаг 2
tögürig ulayan γurban nidütei ss	(11)	(4)	
törülki urγuγsan sira üsütei ss	(11)	(4)	
tügel kümün-i jaγuγsan aray-a-tai v	(12)	(4)	
2. urin gem-üd-i oγtulur-un ss	(9)	(3)	Бадаг 3
uridu barayun γar-tayan üldütei ss	(12)	(3)	
olan sesig-i tarqayar-un ss	(9)	(3)	
ulam nögüge γar-tur gabala-tai v	(11)	(4)	
3. degerükei asuris-i darur-un ss	(11)	(3)	Бадаг 4
degedü jegün γar-tayan jida-tai ss	(11)	(4)	
delgegsen orungγa-tu serige-yi ss	(11)	(3)	
ded doradu γar-tur bariγsan v	(9)	(4)	
4. jalayu turuqan čirai-tai ss	(9)	(3)	Бадаг 5
jaγan-u arasun čamca-tai ss	(9)	(3)	
jarimlan üker-ün arasun-tur ss	(10)	(3)	
jalγaysan ilti niriγubči-tai v	(10)	(3)	
5. bayatur amitu arslan-i ss	(9)	(3)	Бадаг 6
barayun čiken-degen süike-tei ss	(10)	(3)	
(barayan erigen moyai-yi ss	(9)	(3)	
basa jegün čiken degen süike-tei v )	(11)	(4)	
6. .... ss	(0)	(0)	Бадаг 7
..... ss	(0)	(0)	
..... ss	(0)	(0)	
qolbaju küjegün-degen erike-tei v	(12)	(3)	
7. qara nuγud moyai büs-e-tei ss	(9)	(3)	Бадаг 8
qamuγ-a kei metü k(ücütei) ss	(9)	(3)	
γayiqamsiy külüg күрдү ss	(9)	(3)	
qaljan eljige külgetei v	(8)	(3)	
8. köke oγtoryui-daqi naran-i ss	(10)	(3)	Бадаг 9
küisün-ü tuš-iyar urγuγulju ss	(10)	(3)	
köl-iyen temür č(idür)-iyer ss	(9)	(3)	
küsegülün čimegsen maq-a kali v	(11)	(3)	

хэмээн дөрвөн мутарт Махагалийг гадаад талаас нь тэр дундаа эхний бадагт өгүүлэн буй бурхныхаа нүүр царайны онцлог, мутрын тоо, мэлмийн тухай зэргийг өгүүлсэн бол 2, 3 дугаар бадагтаа мутрын байрлал, барьсан зүйл буюу үүргийг нь, 4, 5, (6), 7, 8 дугаар бадагтаа биеийн ерөнхий болоод тусгай онцлог байдал, засал чимэглэл, хувцас, эдлэл хэрэгсэл зэргийг тоочин өгүүлжээ.

Дараагийн 8 бадаг нь:

1. činu dayun-i sonusbasu ss	(9)	(3)	Бадаг 10
čing sümür tay ber ködülüged ss	(9)	(4)	
čisutan dayisad-un jürüken-i ss	(11)	(3)	
činar-ača silgüdkegči maq-a kali v	(12)	(3)	

2.	amurliysan sedkil-tü bögetele ss	(11)	(3)	Бадаг 11
	ada dotqod-i aryuytur-un ss	(9)	(3)	
	ayulaysan činar-i üjegüljü ss	(11)	(3)	
	alar-a kürügči maq-a kali v	(10)	(3)	
3.	eldeb qubilyan ɣaryaju ss	(8)	(3)	Бадаг 12
	erketen tngri asuris-i ss	(8)	(3)	
	esergü öber-tegen sögüdkegsen ss	(11)	(3)	
	erdem-tei boyda maq-a kali v	(9)	(3)	
4.	sayibar oduysan-u ilete ss	(10)	(3)	Бадаг 13
	šasin nom-i ebdegčün ss	(7)	(3)	
	samayui mayui setkil-ten-i ss	(9)	(3)	
	samšiyasuyai gegegen maq-a kali v	(12)	(3)	
5.	edüge tegün ..... ss	(0)	(0)	Бадаг 14
	erdem-ten nom-čin-i saqiyad ss	(9)	(3)	
	ede ele yabuqun amitan-i ss	(11)	(4)	
	engke amurayul maq-a kali v	(10)	(3)	
6.	činar mayui sedkijü bürün ss	(9)	(3)	Бадаг 15
	čiken-dür sayiqan ögülegčün ss	(10)	(3)	
	čisutan dayisun adas-i ss	(9)	(3)	
	činu küčün-iyer buturayul v	(10)	(3)	
7.	nom-un ejen qayan qatun ss	(8)	(4)	Бадаг 16
	nomčün sayid köbegüd ökid ss	(9)	(4)	
	noyad kürged бүгүде-yi ss	(8)	(3)	
	nöküčen sakituyai maq-a kali v	(11)	(3)	
8.	qutuy-tai činu erdem-i ss	(8)	(3)	Бадаг 17
	qolbaju maytaysan buyan-iyar ss	(10)	(3)	
	qotula amitan tonilju ss	(9)	(3)	
	qoyusun boltuyai ene orčiqui v	(11)	(4)	

хэмээн дөрвөн мутарт Махагалийг дотоод мөн чанараас нь магтан шүлэглэхдээ эхний 4 бадагт нь дөрвөн мутарт Махагали бурхны хүчин чадал, эрдэм шидийг өгүүлэхдээ гаргах дуун, ахуй сэтгэл, илрүүлэх увидас талаас нь харилцан бие биенийх нь уялдаанд нэгээс нөгөө нь ундарсан дэс дараалалд магтсан агуулгатай байна. Тэгвэл сүүлийн 4 бадагт нь дөрвөн мутарт Махагали бурхны хүчин чадал, билиг увидаст хандан энэ орчлонгийн буй бүхнийг өөр өөрийнх нь заяа тавилан дахь байр байранд нь сайн сайхан байлгаж, муу бүхнийг даран сөнөөж байхыг гуйгаад эцэст нь эрдэм ухаанаа түгээн дэлгэрүүлж, сайн сайхан сэтгэл, явдалтай бүхнийг гэгээрэлд хүргэхийг даатган залбирсан агуулгатай байна.

Төгсгөлийн хэсэг нь:

9.	ayui erdem-i činu quriyaju ss	(11)	(3)	Бадаг 18
	ayalyun qolban maytayči ss	(8)	(3)	
	ayay-a tekimlig čosgi odsir ss	(10)	(3)	
	al..... ba..... ɣartuyai v	(0)	(3)	
10.	..... ss	(0)	(0)	Бадаг 19
	egsig dayubar ken dayulbasu ss	(10)	(3)	
	ebečün adas anu amurliyad ss	(11)	(3)	
	ečüs-bür burqan boltuyai v	(8)	(3)	

гэсэн хэсэг болно. Эхний бадагт зохиолч уг шүлгийг бичсэн тухайгаа өгүүлээд өөрийнхөө хувийн хүсэл зөгнөлөө илтгэн даатгасан бол сүүлийн бадагт нийт олон түмний хүсэл зөгнөлийг дөрвөн мутарт Махагали бурханд даатган залбирсан агуулгатай байна.

Өгүүлэн буй зүйлүүдийг нэгтгэн авч үзвэл Чойжи-Одсэр билиг авьяаслаг, эрдэм ухаан үлэмж төгс яруу найрагчийн үүднээс “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгээ туурвихдаа бүтэц зохиомжийн хувьд эхлэл, өрнөл, төгсгөл гэсэн дэс дараалалын дагуу дөрвөн мутарт Махагалийг холбон шүлэглэхийн уг үндэс, дөрвөн мутарт Махагалийн гадаад өнгө зүс, хэлбэр галбир, унаа хөлөг зэргийг дотоод мөн чанар буюу эрдэм билиг, увидас чадалтай нь холбон бусдаас товойлгон ялгаруулж шүлэглээд эцэст нь бурхны шашинт хэн бүхнийг ивээл хайрандаа багтааж, мууг дарж, сайныг дэлгэрүүлж байхыг хүсэн даатгасан агуулгатай бүтээл болсон байна.

### **“Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгийн бадаг, айзам хэмнэл, аялгуу холбоц**

Чойжи-Одсэр бандидагийн “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгийн дөрвөн хэсэг тасархай хуудас Э. Хэнишийн “*Mongolica der Berliner Turfan-Sammlung*” II (Berlin. 1959) бүтээлийн 10, 11, 14, 15 дугаар талд нийтлэгдсэн байдаг гэж дээр өгүүлсэн билээ. Уг шүлэг хадгалагдан байгаа Берлиний номын сангийн хөмрөгийн данс бүртгэлийн ТМ 3D 130, ТМ 6D 130 гэсэн хоёр тасархай хуудсан дээр 27, 28 гэсэн хуудасны дугаарыг нангиад тоогоор тавьсан байна. Энэ хоёр тооны учир хийгээд “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгийн бадгийн бүрэн бүтэн байдал зэргийг эрдэмтэн Д. Цэрэнсодном өмнө өгүүлсэн судалгааны бүтээлүүддээ судлан шинжлээд энэ 27, 28 гэсэн дугаар бол Турфаны цуглуулгын 2 дугаар дэвтрийн 13 дугаар талд байгаа Там бирдийн тухай өгүүлсэн 35 шад шүлгийн 9 гэсэн тоо байгаа нь уг нугалмал номын хуудасны дугаар биш харин тэр үеийн барын дэс дугаар болохыг батлаад, тухайн үеийн барын 30 мөргийн зохион байгуулалтаар бодоход “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” нь  $28 \times 30 = 840 + 9 / 849$  шад шүлэг байжээ гэж бодогдохоор байгаа ч үнэн хэрэг дээрээ “Дөрвөн мутарт Махагалийн магтаал”-ын уламжилж ирсэн 68 шад шүлгийн эхний болоод төгсгөлийн хэсгээс үзвэл уг шүлэг эхэлж байгаа нь бас төгсөж байгаа нь тодорхой харагддаг. Тиймд “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлэг харьцангуй бүтэн уламжлагдаж ирсэн гэж үзвэл уг магтаал шүлгийн өмнөх 25 бар буюу 750 орчим шатад нь Чойжи-Одсэр өөрийнхөө баримталдаг ёсны (сажийн ёс) гол гол бурхан шүтээнүүдийг юмуу тусгай уншлагатай байсан бурхдын магтаалыг монгол хэлээр зохиосон байсан байх гэж үзсэнийг бид дэмжиж байна.

“Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгийн уламжилж ирсэн 68 шад шүлгийн бадгийн зохион байгуулалт буюу бадаглал нэлээд тодорхой байна гэж хэлж болно. Учир нь нэг, хоёр, гурав дахь шадын сүүлд давхар цэг (ss), дөрөв дэх шадын сүүлд дөрвөн цэг (v) тавиад толгой, сүүл холбосон байгаагаас үндэслээд уг шүлэг дөрөв дөрвөн шатаар бадагласан онцлогтой болохыг харж болж байна. Мөн үүнийг шүлгийн нийт агуулга ба бадаг тус бүрийн агуулгын уялдаа холбоо давхар баталж байна. Иймд уг шүлгийн эхний болоод дунд хэсгийн дарагдсан шадуудыг тооцоолон үзвэл 19-20 орчим бадаг шүлэг байсан нь тодорч байна.

Бадаг нэг тодорхой утгыг илтгэдэг төдийгүй цаанаа зохиолч хийгээд үндэстнийхээ сэтгэлгээний тодорхой үзэл баримтлал, зүй зохист тогтолцооны

илэрхийлэл болдог. “Дөрвөн мутарт Махагали магтаал” шүлэг тодорхой утга илтгэж, зүй зохист нарийн айзам хэмнэл, аялгуу холбоц бүхий холбоосоор дөрвөн мөрөөр тогтолцоотой үргэлжлэн давтагдсан бадагтай байгаа нь зохиолч улмаар XIV зууны монголчууд дөрвөн улирал, дөрвөн зүг, дөрвөн зовхис ... гээд амьдрал ахуй, зан заншил, соёл сэтгэлгээнийхээ нөлөөгөөр хоёрын үржвэр болсон дөрвөөр шүлэг найргаа бадаглаж, цаашид монгол шүлгийн хөгжил хувьсал мөнхөд дэлгэрэн үргэлжилнэ гэсэн бэлгэдсэн утгатай, нөгөө талаас эрхэлж буй мал адгуусныхаа явдал, мөр зэрэгтэй холбоотойгоор ухаарч бадаглаж байсныг харуулж байна.

Улс үндэстэн бүрийн сэтгэлгээний цөм хэв загварын онцлогт тулгуурладаг шүлгийг үүсгэдэг бадгийн хамгийн бага нэгж нь зохиолчийн ухамсарт төрсөн утгын үр хөврөлийн анхны эсийг тээсэн аялгуугаар айзам хэмнэлтэд тулгуурлан бий болдог. Тиймд бадгийн нэгж буюу хамгийн бага шүлгийг үүсгэхдээ тодорхой утгын үр хөврөл бүхий аялгуулаг айзам хэмнэлт мөр ижил, төстэй үсэг, үе, үгээр урнаар /найран/ холбогдож бүтдэг. Иймд бадаг буюу шүлэг үүсэхдээ мөр шадууд айзам хэмнэл буюу үе үгийн тоо жигд, хоорондоо утга, хэлбэрээрээ уран нарийн холбогдсон байдаг.

Шүлэг буюу яруу найргийг бүтээж байдаг дотоод мөн чанар дахь амин чухал асуудал нь айзам хэмнэл, аялгуу холбоц юм. Яруу найраг туурвигч этгээдийн сэтгэлгээний цөм хэв загвар болсон төрөлх хэл аялгууны эвсэн найрсан хамгийн товч хувилбараар гүнзгий утга санааг тээж илэрдэгийн хувьдаа яруу тунгалаг сонсголонтой, мөнхөд оршин тогтнох дотоод увидасыг өөртөө шингээсэн байдаг. Өөрөөр хэлбэл туурвигч үндэстнийхээ сэтгэлгээний түүхэн хэв загвар, учир утгыг дотоод мөн чанартаа уран сайхны хийсвэр хэлбэрээр буюу айзам хэмнэл, аялгуу холбоцдоо хадгалдаг үнэт чанартай зүйл. Амьсгалын нэг түрэлтээр хамгийн чөлөөтэй урсан гарах үйл явцаар айзам хэмнэлийн асуудал ойлгогддог. Амьсгалын нэг түрэлтээр хамгийн чөлөөтэй хувилбараар шүлгийн нэг мөр буюу шад урсан гарч айзам хэмнэл үүсгэдгийн дотоод мөн чанар нь аялгуутай шууд холбоотой зүйл. Өөрөөр хэлбэл нэг мөрийн айзам хэмнэлийг үүсгэн гаргахад тээсэн утга санаатайгаа уялдуулан тухайн хэлний найран эвсэх зүй тогтлын дундаас хамгийн аязам аялгуулаг буюу нэг үеэс нөгөө үе, тэр үеэс өөр үг, өөр үгнээс дараагийн холбон хоршсон үг, түүнээс шүлгийн мөр ундран гарсан байх тэр хэлбэрийг зохиолчийн авьяас-боловсрол-мэдрэмжийн зангилаагаар сонгож авахыг хэлдэг. Айзам хэмнэлийн дотоод зүй тогтлын асуудал түүнийг үүсгэдэг гол амин сүнс болсон аялгуу цаашлаад хэлний зүй тогтлын мөн чанар дээрээс тулгуурлан шүлэг бичигддэг.

“Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгийн дөрвөн шадар мөрлөсөн бадаглал:

Нэгд, мөр бүрдээ 7-14 үетэй байна. Нарийвчлан үзвэл:

7 үетэй мөр 1 (7)

8 үетэй мөр 8 (64)

9 үетэй мөр 22 (198)

10 үетэй мөр 13 (130)

11 үетэй мөр 18 (198)

12 үетэй мөр 5 (60)

13 үетэй мөр 0 (0)

14 үетэй мөр 1 (1)

68

671 буюу дунджаар нэг мөрөндөө (671/нийт үеийн

тоо/:68 /шадын тоо/=~9,9) 10 орчим үетэй байна. Бадаг тус бүрээр нь авч үзвэл дээрх

үеийн тэнцүү байдал улам ойртож 1-3 үеийн л хэлбэлзэлтэй болж байна. Энэ хэлбэлзэл нь утгаа *нэгд*, нэг мөрөөс нөгөө мөрд шилжихдээ өссөн юмуу буурсан хэлбэрээр үеийн тоо тааруулсан (Бадаг 2, 10, 17) *хоёрт*, бадгийн нэг гурав, хоёр дөрөвдүгээр мөрүүд салаавчлах хэлбэрээр үеийн тоо тааруулсан (Бадаг 3, 6, 15, 16), *гуравт*, бадгийн нэг дөрөв, хоёр гуравдугаар мөрүүдийг хаших хэлбэрээр үеийн тоо тааруулсан (Бадаг 11, 13), *дөрөвт*, бадгийн нэг хоёр, гурав дөрөвдүгээр мөрүүдийг зэрэгцүүлсэн хэлбэрээр үеийн тоо тааруулсан (Бадаг 5, 9, 12) байна. Ийнхүү бадаг дахь мөрийн үеийн тоог нэгдүгээр мөрнөөс нь өсгөх юмуу бууруулах, эсвэл хаших, салаавчлах, зэрэгцэх холбоцд захируулан үеийн тоог журамлан тогтоосон байгаа нь монгол шүлгийн тогтолцооны өвөрмөц нэгэн онцлог болох нь харагдаж байна.

Шүлгийн үе тухайн шүлгийг эгшиглэнтэй яруу тунгалаг болгодог гол зүйл. Тийм ч учраас судлаач онолчид “*Аливаа шүлэгт эгшиг дуун бол шүлгийн гол яс болно*”<sup>51</sup> гэж онцлон өгүүлсэн байна. “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгийн мөрийн үеийн тоо аль болохоор тэнцүү байхыг эрмэлзсэн, тэр дундаа бадаг дотроо бараг ижил байна.

**Хоёрт**, мөр бүрдээ 3-4 үгтэй байна. Нарийвчлан үзвэл:

3 үгтэй мөр 55 (165)

4 үгтэй мөр 13 (52)

**68**

**217** (Уг шүлгийн уламжилж ирсэн 68 бадагт орсон

үеийн тоо). Үүнээс харахад мөр бүрд болоод бадагт орсон үгийн тоо бараг ижил 3 байна. Зарим цөөн бадагт л 4 үгээр мөр тэнцүүлсэн байна.

Дээрх үе, үгийн тооны тооцооноос үзвэл “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлэг бадгийг үүсгэж буй мөрийн тоо, улмаар мөрийн үе, үгийн тоог аль болохоор тэнцүү байлгахыг эрмэлзсэн онцлогтой байна.

Шүлэгт аялгуулаг айзам хэмнэл бүхий үе, үгийн тоо тэнцүү мөрүүд нэн чухлын зэрэгцээ тэр шадуудыг хооронд нь холбосон холбоцууд бас чухал зүйл байдаг. “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлэгт:

Нэгд, шүлгийн мөр бадгийн үеийн хэлбэлзлийн зөрөөг голлон тохируулж яруу сонсголонтой байлгах давхар үүрэг бүхий толгой холболтыг маш нарийн тохируулсан байна. Учир нь бүх бадгийг үсгээр (Бадаг бүгд), үеэр (Бадаг 1, 2, 4, 5, 6, 9, 10, 13, 15, 17, 18), үгээр (Бадаг 16) ижилсүүлэн толгой холбосон төдийгүй үеэр зэрэгцүүлэн (Бадаг 10), салаавчлан (Бадаг 2, 11), мөн ижил дуудлагатай юмуу ижил хэмжээний үгээр ижилсүүлэн толгой холбосон (Бадаг 3, 9) байна. Үүнээс үзэхэд уг шүлэгт толгой холболтыг нэн чухалчлан үзэж, шүлгийн (бадаг тус бүрийн) утгад дулдуйдсан, мөр бүрийн үе-үгийн хэмжээтэй дотоод мөн чанартаа нарийн уялдсан олон ур маягийг чадварлаг ашигласан нь Чойжи-Одсэр найрагчийн урлах авьяасыг харуулаад зогсохгүй монгол шүлэгт толгой холболт чухал зүйл болохыг баталж буй хэрэг юм. Шүлэг зохиол бол туурвигч үндэстнийхээ сэтгэлгээний ерөнхий хэв загварын илрэл байдгийн хувьдаа өөрийн гэсэн тус тусын өвөрмөц онцлогтой байдаг. Энэ талаар их зохиолч В. Инжаннаши “Хөх судар” романыхаа товчит тольтын 6 дугаар ангид “*Үлгэрлэвээс ертөнцийн уур амьсгал туйлын сайхан өнгөт нь цэцэг атал цэцэг бүр адилгүй өөр өөртөө нэгэн зүйлийн сайхан өнгө бий. ... Үзтэл иргэн үгс сүүл даран хэлж, монгол үг толгой холбон өгүүлэх, төвд үсэг түргэн дөтийг эрхэлж, манж үсэг тус тааруулан зохиочихуй*”<sup>52</sup> гэж өгүүлсэн бол эрдэмтэн Ц. Дамдинсүрэн “Толгой холбох нь

<sup>51</sup> Дамдинсүрэн Ц. *Монгол хэл бичгийн тухай*. Уб., 1957. 38 дугаар тал

<sup>52</sup> Инжаннаши В. *Хөх судар*. Тэргүүн дэвтэр. Хөх хот., 1959. 57 дугаар тал

үргэлжилсэн зохиолд чимэг болоод шүлэгт тулгуур болно”<sup>53</sup> хэмээн өгүүлсэн байна. Энэ саналыг монгол шүлгийг судласан монголч эрдэмтэн А. М. Позднеев<sup>54</sup>, П. Пеллио<sup>55</sup> нар ч бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрсөн байдаг.

Хоёрт, Толгой холболтын нэгэн адил үүрэг бүхий ч шадын төгсгөлийг ижилсүүлэн журамладаг сүүл холболтыг уг шүлэгт түгээмэл ашигласан байна. Тэр дундаа урт хос эгшиг юмуу задгай үеэр ихэвчлэн сүүл холбожээ. Энэ нь монгол хэлний эгшиг зохицох хуультай холбоотой зүйл юм. Тодруулбал, 7, 8 дугаар бадгаас бусад бадаг бүгд задгай үетэй, тэр бүгд эгшгээр ерөнхийдөө ижилсэн сүүл холбогдсон ч, хаших (Бадаг 2, 4), салаавчлах (Бадаг 3, 6) аргаар сүүл холбосон онцлогтой байна. Иймд уг шүлэг сонсоход яруу сонсголонтой, уншихад гүн утгатай, өвөрмөц нарийн бүтэц тогтолцоо бүхий шүлэг болох нь харагдаж байна.

### “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгийн уран дүрслэлийн зарим онцлог

Уран зохиолын онолын ойлголт, үзэл баримтлалаас харахад зохиол бүтээлийн үндсэн суурь ай (категори) нь гүн ухаан-үнэн-уран сайхны төгс хослол байдаг. Шүлэг найргийн уран дүрслэлийн асуудал онцлон авч үзүүштэй гол зүйлийн нэг байдаг. “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгийн 2-9 дүгээр бадагт Махагали бурхныг хөрөглөн дүрсэлжээ. Хөрөглөх дүрслэл бол дүрийн гадаад, дотоод онцлог мөн чанарыг бусдаас онцлон дүрсэлдэг зохиомжийн нэг хэсэг зүйл. Энэ утгаар нь авч үзвэл зохиолч өөрийхөө шүтэж байсан, ер нь бол монголд шүтэгдэж байсан дөрвөн мутарт Махагалийг бусад Махагалиудаас ялгаж дөрвөн гартай, энэ дөрвөн гарийнхаа урд талын баруун гарт илд барьсан, хойт талын баруун гартаа гавал барьсан, зүүн урд гараа өргөж жад барьсан, зүүн хойт гараа мөн өргөж сэрээ барьсан, төв тэгш дүүрэн харсан гурван нүд, шар үстэй, бүтэн хүнийг араандаа зуусан догшин хэрцгий, хүйс нь ил гарсан, зааны арьсан цамцтай, үхрийн арьсан нуруувчтай, могойн бүстэй, баруун чихэндээ арслангийн дүр бүхий ээмэг, хүзүүндээ эрхи зүүсэн, хөлдөө төмөр цагираган гинжтэй, халзан илжиг хөлөглөсөн залуухан Махагалийн дүрийг нэг бүрээр нь тоочин хөрөглөж дүрсэлсэн байна. Ингэж хөрөглөхдөө нэгд, бие эрхтэн тус бүрийн үүргийг давхар харуулсан гэж хэлж болохоор байна. Жишээ нь, баруун талын хоёр гараараа дороос болоод дэргэдээс ирэх элдэв муу гэм хор, сэтгэл сэжгийг илддэн дарах, зүүн хоёр гараараа дээрээс ирэх атаа хорсол, аврал энэрэлгүй бүхнийг жадлах, сэрээдэн зайлуулах, гурван нүд нь үргэлж сонор сэрэмжтэй харж байх, араа шүд нь муу муухай бүхнийг тасдан хаяж байхаар дүрслэгдсэн байна. Хоёрт, өргөсөн гарнаас эхлүүлэн нүд, үс, шүд, өмссөн цамц, зүүсэн зүүлт, унасан унаа, хөлийн цагираган гинж хүртэл дээрээс дэс дараалуулан доошилж тоочсон хэлбэрээр хөрөглөсөн байна. Энэ нь бурхны дүрийг урладаг тухайн үеийн дэс дараа, үгүй дээ л зохиолчийн үзэл баримтлалын зүй тогтлыг харуулж байгаа хэрэг юм. Гуравт, Махагали бурхныг “залуу турьхан” гэж онцлон дүрсэлсэн нь Махагали бурхны залуу бага дүрийг илэрхийлэх төдийгүй монголчууд Махагали бурхныг шинэ тутам шүтэх болсныг давхар илэрхийлсэн биз. Мөн “турьхан” туранхай гэж хөрөглөсөн нь ажил үүргийн хувьд ихтэй байсан шинжийг илт

<sup>53</sup> Дамдинсүрэн Ц. *Монгол хэл бичгийн тухай*. Уб., 1957. 38 дугаар тал

<sup>54</sup> Позднеев А. М. *Образцы народной литературы монгольских племен*, вып. СПб., 1880. стр. 323

<sup>55</sup> Pelliot P. *Histoire secrète des Mongols*. Paris., 1949. p. 136

илэрхийлэн гаргасан. Үүнийг уг шүлгийн өрнөл хэсгийн хоёрдугаар хагаст ажил үүрэг, ид шидийг илэрхийлэн гаргаснаар батлагдана. 10-17 дугаар бадагт Махагали бурхны дотоод мөн чанар, увидас чадлыг гадаад хөрөг дүртэй нь уялдуулан дүрслэхдээ дууг нь сонссон сайн сайхан явдалтангууд баясан цэнгэж, муу муухай явдалтнууд айн дагжиж байдаг тухайг урнаар өгүүлсэн байна.

“Дөрвөн мутарт Махагали”-ийн гадаад хөрөг дүрслэл, хүч чадал, ажил үүргийн онцлогийг гаргахдаа уран дүрслэлийн ихэсгэл багасгал, адилтгал зүйрлэл, хэтрүүлэл, чимэг үг зэргийг чадварлаг ашигласан нь уг шүлгийн уран сайхан шинж, уг бурхны монголжуу шинжийг давхар давхар харуулсан байна. Тухайлбал, 5 дугаар бадагт “*jalayu turuqan čirai*”, “*jaγan-u arasun čamca*”, “*jarimlan iker-ün arasun*” ... гэж Махагали бурхны дотоод, гадаад мөн чанар, гоёл чимгийг тодруулан гаргахдаа чимэг үгийг оновчтой ашигласан нь “Дөрвөн мутарт Махагали бурхан”-ыг илт онцолсон төдийгүй уг зохиолын хэл найруулгын зүй зохист сонголтыг давхар харуулж байна. “Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлгийг зохиолч тухайн үеийн нэгэнт хэвшин тогтсон бичгийн хэлний хэм хэмжээг баримтлан холбон найруулах арга ухаан, авьяас билгийн үүднээс урнаар шүлэглэн магтаж чадсаны илрэл юм. 10 дугаар бадагт уран дүрслэлийн ихэсгэлийн аргыг чадамгай ашиглаж, “*činu dayun-i sonusbasu, cing sümür tay ber ködülüged*” хэмээн Махагали бурхны том товир бие, хүч чадлыг урнаар утга шилжүүлэн илэрхийлэн гаргасан онцлогоос тодорхой харагдаж байна.

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэж үзвэл:

Чойжи-Одсэр бол XIV зууны эхэн үеэр буюу 1305-1321 оны үед хааны ивээлд багтаж эрдэм ухаанаа зориулан Дайдугийн гэрэлт цагаан суваргат сүмд сууж, бурхны шашны олон судар шастирыг монгол хэлнээ хөрвүүлж, зохиол бүтээлээ бичиж байсан бандида юм.

“Дөрвөн мутарт Махагалийн магтаал” шүлэг XIV зууны үеийн монгол шүлгийн хэлбэр хэмжээ, бүтэц зохиомж, бадаглал, уран дүрслэл, утга сэдэв, агуулга хэлбэрийн нэгдэл тогтолцоо зэрэг олон талын онцлогийг бүрэн харуулж байна.

Чойжи-Одсэрийн шүлэг найргийн туурвил зүйн арга барил, ур маяг, орчуулгын болоод хэл зүйн бүтээлийнх нь онцлогоос харахад монгол хүний аж амьдрал, ахуй сэтгэлгээ, хэл соёлын цөм мөн чанарт бүрэн дүүрэн тулгуурласан байгаа нь түүнийг уугуул монгол хүн байсныг баталж байна.

### Ном зүй

1. Бира Ш. *Шагдарын Дамдины “Алтан дэвтэр” гэдэг номын тухай*. ШУ сэтгүүл. Уб., 1960
2. Weller F. *Zum Blockdruck fragmente des Mongolischen Bodicaryāvatāra der Berliner Turfansammlung*. (ADAWB.KSLK Jahrgang 1954. №2) Berlin., 1955
3. Weller F. *Zum Mongolischen Tanjur, Berichte über die Verhandlungen der Sächsischen Akademie der Wissenschaften zu Leipzig, Philologische-historische Klasse Band 97.*, 1949
4. Weller F. *Zum Blockdruck fragmente des Mongolischen Bodicaryāvatāra der Berliner Turfansammlung, Abhandlungen der Deutschen Akademie der Wissenschaften zu Berlin. Klasse für Sprachen, Literatur und Kunst Jahrgang.*, 1954
5. Владимирцов Б. *Монгольская литература*. Литература Востока. вып. 2, СПб., 1920
6. Garudi. *Turfan-ača oldaysan “Dörben muturtu Maqakali-yin maytayał” kiged tegün-dü qolbuydaqu jarim asayudal*. ÖMYSESB., 1996. №4
7. Garudi. *Dörben muturtu Maqakali-yin ungsily-a üsüglel kiged seyiregüül tayilburi*. ÖMYSESB., 1997. №3

8. Дамдинсүрэн Ц. XIV зууны үеийн монгол хэл бичгийн эрдэмтэн Чойжи-Одсэр. ШУ-ны хүрээлэнгийн бүтээл. №2, Уб., 1957
9. Дамдинсүрэн Ц. Монгол хэл бичгийн тухай. Уб., 1957
10. Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм. Хоёр дахь хэвлэл. Уб., 1999
11. Жамба Асрагч нэртийн түүх. Monumenta Historica., Том II. Fasc 4. Уб., 1960
12. Жанчив Ё. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд. Уб., 2005
13. Жүгдэр Ч. Развитие философской мысли Монголии в XIX веке. М., 1964
14. Инжаннаши В. Хөх судар. Тэргүүн дэвтэр. Хөх хот., 1959
15. Cleaves F. W. *The Bodistw-a Cari-a Awatar-un Tayilbur of 1312 by Čosgi Odser*. HJAS.vol 17. №1., 1954
16. Ligeti L. *A propos de la version mongole des "Douze actes du Bouddha"*. Acta Orient. Hung. Tom XX., 1967
17. Лувсанвандан Ш. Орчин цагийн монгол хэлний зүй. Тэргүүн дэвтэр. Уб., 1967
18. Лувсанданзан Алтан товч. Хэвлэлд бэлтгэсэн Ц. Шагдар. Уб., 1957
19. Надмид Ж. Монгол хэл түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм. Уб., 1967
20. Пагва Т. Зурхний тольтын тайлбарыг судалсан тухай тэмдэглэл. Уб., 1957
21. Pelliot P. *Sur quelques mots d'Asie Centrale attestés dans les textes chinois*, JA, Onzième série., 1913
22. Pelliot P. *Les systèmes d'écriture en usage chez les anciens Mongols*. AM., 1925
23. Pelliot P. *Histoire secrète des Mongols*. Paris., 1949
24. Позднеев А. М. *Образцы народной литературы монгольских племен*, вып. СПб., 1880
25. Позднеев А. М. *Лекции по истории монгольской литературы*. СПб., 1896
26. Roerich G.N. *Kun-mkyen čhos-kyi hod-zer and the origin of the Mongol alphabet*. Journal of the Royal Asiatic Society of Bengal., 1945
27. Roerich G.N. *Монголо-Тибетские отношения в XIII-XIV вв.* Филология и история монгольских народов. М., 1958
28. Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй. Тэргүүн дэвтэр. Уб., 1964
29. Саган Сэцэн Эрдэнийн товч. Monumenta Historica., Том I. Fasc 1. Уб., 1960
30. Sagaster K. *Hat Čos kyi odser die Pāncaraksa ins mongolische üdersetzt?*. Олон улсын монголч эрдэмтний II их хурал. Боть II. Уб., 1973
31. Төмөртоогоо Д. Монгол хэлиинжилэлийн онол, түүхийн асуудлууд. Уб., 2002
32. Haenisch E. *Mongolica der Berliner Turfan-Sammlung*. II. Mongolische Texte der Berliner Turfan-Sammlung in Faksimile. Berlin., 1959
33. Kesigtoятаqu Č. *Mongyol-un erten-ü udq-a jokiyal-un sin-e sudulul*. Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a., 1999
34. Цэрэнсодном Д. *Об одном стихотворении из Турфанского сборника*. Доклады монгольской делегации на XXVI конгрессе Востоковедов. Уб., 1963
35. Цэрэнсодном Д. *Турфаны цуглуулгын ТМ /5/ D 130*. Studia Mongolica. Tom VII., Fasc 3. Уб., 1969
36. Цэрэнсодном Д. XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр. Уб., 1969
37. Цэрэнсодном Д. Монголын уран зохиолын товч түүх. (XIII-XX зууны эхэн) Уб., 2002

## SUMMARY

Choji-Odser, a Mongolian scholar, lived at the White Stupa of Dadu during the period of XIV century or 1305-1321 and translated many works from Sanskrit and Tibetan into Mongolian.

The Praise of Mahakala is a Mongolian Buddhist poem, which describes entirely the traditional Mongolian poetical style, rhyme, structure, composition, stanza, depiction and form.

Analyzing from the translation and linguistic peculiarities and method of poetry, his works based on the nature of language, culture, thinking and lifestyle of Mongolians that proved him to be a native Mongolian.